

УЛС ТӨР

ИРЭХ МЯГМАР ГАРАГТ ОЙН
ТҮЙМЭРТ ЗОРИУЛЖ
ҮҮЛ БУУДНА ГЭВ

II нүүрт

ЦАГ ҮЕ

С.БАТЦЭЦЭГ: ЭРЧҮҮД
ХОЁР ДАХЬ ЗҮРХЭНДЭЭ САНАА
ЗОВОЛТГҮЙ БОЛЛОО

VIII нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр

Монголчууддаа
баярлалаа

ХЭНЮУХЭЛЭВ

Н.БАТЗАЯА

Монголын нэрийг дэлхийд гаргаж яваа томоохон аж ахуйн нэгж бол "Товь" хувьцаат компани. Олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалтын үеэр гадаадын төлөөлөгчдөд өгөх бэлгийн тэргүүнд тус компанийн ноолууран бүтээгдэхүүн л явдаг. Монгол Улсын ууган үйлдвэрийн нэг, улсын төсөвт их хэмжээний татварыг байршуулагч, 2000 гаруй хүнийг ажлын байраар хангадаг гээд дурьдаад байвал энэ компанид сайн зүйлс олон. Гэвч өчигдөр нэгэн харамсалтай хэрэг гарч, тус компанийн дээврийн хэсэгт гал гарсан юм. Тодруулбал, Хан-Уул дүүргийн III хороонд байрлах "Товь" хувьцаат компанийн үйлдвэрийн дээвэр шатаж буй талаархи дуудлага Нийслэлийн онцгой байдлын газарт энэ сарын 14-ний 20:46 цагт иржээ.

Үргэлжлэл нь III нүүрт

Г.АНЧИМЭГ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль үргэлжилж байна. Ерөнхийлөгчид нэр дэвшсэн гурван эрхийн хэлж буй үг олны анхааралд яг энэ цаг үед хамгийн их өртөж буй билээ. Тиймээс тэдний хэлсэн үгийг "Хэн юу хэлэв" булангаараа хүргэе.

Х.Баттулга: Нэг улсаас 100 хувь хараат болсны дараа дуугарвал оройтно

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын "Монголын" гэдэгүриаг зарим сонгогч ойлгохгүй байгаагаа илэрхийлж, "Ямар дайн байлдаанд орох гэж байгаа биш" гэж цахим орчинд бичиж байлаа. Тэгвэл нэр дэвшигч Х.Баттулга "Өнөөдөр Монгол Улс нэг хүнд ногдох газар нутаг, байгалийн баялаг, малын тоогоороо дэлхийд нэгдүгээрт ордог. Дэлхий дээр 200 гаруй улс байгаа. Тэр олон

Үргэлжлэл нь III нүүрт

улсаас дээрх үзүүлэлтээрээ тэргүүлж байна. Газрын дороо баялагтай. Дээрээ ч баялагтай. Тэр нь газар тариалан, мал аж ахуй. Монголын мал сүрэг 61 сая хүрчихээд байна. Гэтэл энэ их баян орны иргэд ямар байдалтай байгаа билээ. Өнөөдөр өр зээлгүй хүн байна уу. Тэтгэврийн зээл, оюутны төлбөр төлөх гээд зээл аваагүй, лизингийн зээлгүй хүн Монголд бараг алга. Тийм болохоор зээлгүй хүн байна уу гэж асуухаар гараа өргөх хүн олдохгүй байна. Монголд ажилгүйчүүдийн тоо 250 мянгад хүрчихлээ. Би "Монгол ялна" гэсэн уриа үг дэвшүүлээд байгаа нь монголчууд 30-хан гэр бүлийн төлөө борив бохисхийлгүй ажиллах уу. Гурван сая монголчууд нэгдэн нягтарч өөрсдийнхөө сайн сайхны төлөө хамтрах уу гэдгийг л яриад байгаа юм. Надаас МАН-ын дэмжигчид болоод зарим хүмүүс асууж байгаа. Хэнтэй байлдаж, хэнийг ялах гээд байгаа юм гэж. Өнөөдөр Монгол Улс эдийн засаг тогтворгүй, нэг улсаас хэт хараат байдалтай байгаа. Үүний эсрэг би болоод журмын нөхөд минь "байлдаж" ялах гээд байгаа юм гэж би харуулна.

ХЭН НЬ ХЭН БЭ



Гэрээ зургаа Г.АРТУУЖИН

ДАРХАНЧУУДЫН ДААЛГАВРЫГ ӨВӨРТӨЛСӨН ГУРАВ

Х.НОРЖИН

"Хэн нь хэн бэ" булан таань монгол төрийн түшээдийн хэн нь хэн бэ, олноо нь хэн байв, одоо хэн болсон, юу хийж байна, сонгогчдынхоо итгэл найдварыг дааж чадах түшээ мөн үү гэдгийг тольдон уншигчиддаа хүргэж байгаа билээ. Өмнөх дугаартаа УИХ-ын 1-13 тойргийн гишүүдийг онцолж, нэр дэвшигчдийн налтар цаашиаад төр түших ажлаа хэр хийж буй талаар нь өгүүлсэн. Тэгвэл энэ удаагийн дугаарт, УИХ-ын 43 дугаар тойрог болох Дархан-Уул аймагас УИХ-ын гишүүнээр сонгогдсон УИХ-ын гишүүн, МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхяраа, УИХ-ын гишүүн, нутгийн удирдлагын дэд хорооны дарга Б.Жавхлан, Б.Баттөр нарныг онцолж байна. Ирэх долоо хоногийн дугаартаа 14-р тойрог буюу Дорнод аймагийн түшээг бид онцлох болно.

Дэлгэрэнгүйг V нүүрнээс

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017



Я.Санжмятав: Баттулга шиг зүрх сэтгэлтэй хүн л энэ том бүлэглэлийн эсрэг сөрж зогсч чадна

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулга энэ сарын 14-нд Увс аймгийн иргэд, сонгогчидтой уулзалт хийлээ. Энэхүү уулзалтад Монгол

Улсын Гавьяат тамирчин, Хөдөлмөрийн баатар, Олимпын хүрэл медальт, дэлхийн аварга Х.Цагаанбаатар оролцож, төрөлх нутгийнхаа зон олонд хандаж үг хэллээ. Тэрбээр "Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч

Халтмаагийн Баттулга өнөөдөр манай нутагт хүрэлцэн ирж, та бүхэнтэй уулзаж байна. Би хувь хүн талаасаа ямар хүн бэ гэдгийг нь хэлэхээр энд ирсэн юм. Түүнээс гадна, Олимпын аварга Н.Түвшинбаяр найзыгаа би манай нутагт ирээч гэж олон удаа гуйсан. Яагаад гэвэл би Увс нутгаас Олимпын аварга төрөөсэй гэж хүсч явдаг. Хувь зохиолоор анд минь манай нутагт ирлээ. 2020 онд Увс нутгаас Олимпын аварга төрөх болтугай. Монголын жүдочид тив, дэлхийд бадхам сайхан амжилт гаргаж байгаа.

Үргэлжлэл нь II нүүрт

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

Г.Доржзодов: ЧАМАЙГ "ЗОРИГИЙН ХЭРЭГ ШИГ БОЛГОНО ШҮҮ" ГЭЖ УДАА ДАРАА СҮРДҮҮЛСЭН

Н.БАТЗАЯА

МАН-ын Стратегийн багт ажиллаж байсан Г.Доржзодовгэх залуу МАН-ын дарга М.Энхболд, Ц.Сандуй, түүний зөвлөх А.Ганбаатар нарын цахим орчинг хакердах, албан тушаалыг мөнгөөр үнэлэх тухай ярьж буй бичлэгийг олон нийтэд цацсан. Улмаар түүнийг өчигдөр өглөө цагдаагийн байгууллагаас баривчлах, тагнах чагнах, мөрдөх асуудал хэрээс хэтэрсэн учраас Хүний эрхийн хуульч, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэлийн гэрт нуугдаж байгаагаа мэдэгдсэн билээ. Хууль хяналтын байгууллагуудын Хан-Уул дүүргийн "Оргил" хотхонд байрлах УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэлийн гэрт ирсэн ч дотор нь орж чадаагүй юм. Учир нь хуулийн дагуу АНУ-ын иргэний гэрт цагдаагийн байгууллагуудынхан

зөвшөөрөлгүйгээр шууд дайран орох хориотой байдаг аж. УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэлийн нөхөр АНУ-ын иргэн билээ. Цагдаагийнхан Г.Доржзодовыг баривчлах гэж байна гэх сургаар түүнийг хамгаалахаар иргэд гэрийнх нь гадаа цугларсан байна. Энэ үеэр Г.Доржзодов "Цагдаагийнхан хамгаалалт гаргасан гэж худлаа хэлсэн. Өнгөрсөн жилээс эхлээд удаа дараа миний амь насанд заналхийлсэн. Хамгийн сүүлд гэхэд өнгөрсөн дөрөвдүгээр сард ТЕГ-аас баривчилж, 133.1 дүгээр заалтаар эрүүгийн хэрэг үүсгэсэн. Хэрвээ намайг хамгаалж байгаа бол хотхоныг бүслэх нь утгагүй" хэмээсэн юм. Мөн 60 тэрбумын наймаа үнэн гэдгийг батлах гэрэл зургийг ч төд удахгүй дэлгэхээ мэдэгдлээ.

Үргэлжлэл нь III нүүрт

19 ДЭХ ЖИЛДЭЭ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ 19800

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах		Авах	Зарах		
АМ.ДОЛЛАР	2360.00	2379.00	ФУНТ	2973.00	3071.00	АМ.ДОЛЛАР	2360.00
ЕВРО	2620.00	2687.00	РУБЛЬ	40.40	42.30	ЕВРО	2621.00
ИЕН	21.45	21.76	ЮАНЬ	347.00	350.50	ИЕН	21.28
						АВАХ	ЗАРАХ
						АМ.ДОЛЛАР	2360.00
						ЕВРО	2621.00
						ИЕН	21.28
						ФУНТ	2979.00
						РУБЛЬ	40.17
						ЮАНЬ	347.50
							3059.00
							43.24
							350.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

Я.САНЖМЯТАВ: БАТТУЛГА ШИГ ЗҮРХ СЭТГЭЛТЭЙ ХҮН Л ЭНЭ ТОМ БҮЛЭГЛЭЛИЙН ЭСРЭГ СӨРЖ ЗОГСЧ ЧАДНА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Нэг биш бүх жинд өрсөлдөж чадаж байна. Яагаад гэвэл Халтмаагийн Баттулга гэдэг хүн Монголын жудод хариуцлагын тогтолцообийн болгоосон. Бэлтгэлээ сайн хийж, амжилт гаргахгүй бол дараагийн тамирчинд нь боломж олгож, тэмцээнд явуулдаг. Ингэж хариуцлагын тогтолцоог жудод бий болгосноор Монголын бөхчүүд амжилт гаргадаг болсон. Энэ хүн 2008 онд Н.Түвшинбаяр маань аварга болоход, 2012 онд С.Ням-Очир маань Олимпын наадмаас хүрэл медаль хүртэхэд, 2016 онд Увс аймгийн Баруунтуруун сумын харьяат Доржсүрэнгийн Сумъяа аваргын төлөө гарч ирээд, булхайтай шүүлтийн улмаас хожигдоход бидэнтэй хамт уйлаад л байж байсан. Бидний төлөө гэсэн сэтгэлээр хандаж, нулимсаа унагаж л явдаг хүн. Бидэнд аавын минь оронд аав. Ахын минь оронд ах, андын минь оронд анд болж чаддаг, эгэл жирийн монгол эр хүн. Эгэл бор амьдралаас хөдөлмөрлөж байж өнөөдрийн өндөрлөгт хүрсэн. Амьдралын маш том сургуулийг төгссөн. Зарим хүмүүс түүнийг боловсролгүй гэж ярьж, сөрөг пиар хийж байна. Боловсрол гэдэг бол эхлээд боловсор, аливаа зүйлд бэлэн бол. Дараа нь тэр зүйлээ ол гэсэн утгатай үг. Монгол Улсын боловсролын зорилго бол эрүүл чийрэг бие бялдартай, оюуны зохих чадвартай, хүмүүнлэг, нийгэмд биеэ даагаад хөгжих боломжтой иргэнийг бэлтгэхэд оршдог юм. Баттулга ах бол амьдралын том боловсролыг эзэмшсэн. Хүнийг хайрлах, энэрэхийг мэддэг. Ялагт, ялагдлын гуниг, баярыг мэддэг, урсгасан хөлсний үнэ цэнийг ойлгодог хүн.



Аливаа хүнийг араас нь түлхэж чаддаг. Амаа аваад давхивал хазаарлаж ч бас чаддаг эр хүн. Яг ийм л эх оронч, чин сэтгэлтэй, шударга Ерөнхийлөгч Монголд ус агаар мэт хэрэгтэй байна. Тиймээс Халтмаагийн Баттулга нэр дэвшигчийг дэмжээрэй гэж уриалъя. Монголын ард түмний төлөө цохилох зүрхтэй, эх орныхоо төлөө зүтгэх итгэлтэй хүн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байгаад үнэхээр баяртай байна. Халтмаагийн Баттулга нэр дэвшигчийг хамтдаа дүнд монголчууд бид сонголттой нийгмийг цогцлоон бий болгож, улам бүр баталгаажуулахын төлөө өдгөө долоо дахь удаагаа улс төрийн сонгуульд саналаа өгөөд байна. Бидний сонголтын үр дүн зөв, буруу байсан эсэхийг гагцхүү цаг хугацаа харуулдгийг 2016 оны УИХ-ын сонгуулиас бэлээхэн

харж болох биз ээ. Миний сонсч, дуулж, харж байгаагаар нэг жилийн өмнө хийсэн бидний сонголт тийм ч оновчтой, үр дүнтэй сонголт байсангүй ээ. Нийгмийн уур амьсгал, сонгогч олны санал сэтгэгдэл тийм ч сайнгүй байгааг хэн бүхэн харж байгаа. Төлбөрийн дарамтад орсон эдийн засаг, эрүүл мэндийн салбарын уналт доройтол, ажилгүйдэл газар авч, эрх тэгш байдал алдагдсан, хууль, шүүхийн байгууллагын үйл ажиллагаа хараат болсон, хэрэгжилт нь дутагдаж буй засаглал, үндэсний үнэт зүйлээ гэсэн ард түмэн гээд болж бүтэхгүй бүхэн ард түмний дунд яригдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ч цацагдаж байна. Иргэдийнхээ мэдэх эрхэнд халддаг, эх орноосоо урвасан хэргийг хэрэгсэхгүй болгодог, өрийн босгыг 105 хувь болгоно гэхчлэн олон таагүй мэдээлэл биеллээ олж эхэллээ. Энэ бидний сонголт байсан юм гэж үү. Улс орны хэмжээнд

яригдаж буй энэ асуудлыг анхаарч үзэхийн дээр аймгийнхаа хэмжээнд харьцуулан харж сууна. Төсөв хэтрүүлсэн Засаг даргатай, хямрал нэрээр ажлаа зогсоосон албадугдтай ийм л төрийн байгууллага аймаг, орон нутгийг авч явж байна. Хямарсан гэх мөртлөө аймгийн Засаг дарга нь Тамгын газартаа дөрвөн шинэ машин авдаг, орон тоогоо дураараа нэмдэг, хэний ч зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар төрийн 200 гаруй албан хаагчийг ажлаас нь халдаг. Үүний үр дүнд 80 гаруй сая төгрөгийн шийтгэврийн буцаан олголтыг шүүхээс гаргадаг гэхчлэн хууль бус үйлдэл хэргийн түймэр шиг газар авлаа. Тиймээс энэ төрд хяналт, хазаар хэрэгтэй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийг ажлаас энэ үйл хэргийг хоёргүй сэтгэлээр гүйцэтгэж, ард түмнийхээ талд зогсч чадах чин шударгуу хүн бол Халтмаагийн Баттулга байна гэдэгт итгэлтэй байна. Хэний ч

гэм буруутай нь тогтоогдоогүй байхад хэрэг зарга тохоодоггүй, хэлмэгдүүдэггүй төрийн тэргүүн байж чадах хүн бол Халтмаагийн Баттулга юмаа. Хийсэн нь нүднээ илхэн, хэлж ярьдаг нь үнэн байдаг энэ хүнийг Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч болгож, жилийн өмнө хийсэн сонголтын алдаагаа засахад иргэн бүрийн оролцоо чухал болжээ. Төр ганхаж буй энэ эгзэгтэй цаг үед монголчууд бидэнд хэлсэндээ хүрдэг, эх оронч Ерөнхийлөгч хэрэгтэй. Энэ удаагийн сонгуульд нам гэхээсээ илүүтэй хүнийг нь харж сонгох нь улс орны тусгаар тогтнол, төр улсын дархлаатай холбоотой чухал асуудал болоод байна” гэлээ. Нэр дэвшигч Х.Баттулга Увс аймгийн иргэд, сонгогчидтой уулзсаны дараа Завхан аймгийн зорив. Энэ үеэр УИХ-ын гишүүн Я.Санжмятав “Завханчууд маань Их хурлын сонгуулиар ялж болсон юм чинь Ерөнхийлөгчийн сонгуульд яагаад ялж болохгүй гэж. Энэ удаагийн

Ерөнхийлөгчийн сонгууль хүч тэнцвэргүй нөхцөлд явагдаж байгааг та бүхэн мэдэх байх аа. Сонгуулийн сурталчилгаа эхлээд ес хонож байна. Нөгөө хоёр нэр дэвшигч маань онгодоор нисээд байгаа. Шунгинасан онгодоор алслагдсан аймгууд руу ганц цаг ч хүрэхгүй хугацаанд нисээд очихно. Сонирхоодиргэнийн нисэх рүү, хувийн авиа компаниуд руу хандсан юм. Агаарт нисдэг хамаг л онгоцыг нь аваад явчихаж. Нэг жижигхэн нисдэг тэрэг байсныг нь Энхбаяр гуайн талынхан мөнгө зоосыг нь төлөөд түрүүлээд авчихсан сурагтай. Ингээд манай хүнд нисдэг тэрэг олдохгүй болов оо. Гэтэл нэр дэвшигч маань хэлж байна “Юун төлөө дөрвөн жил зам харгуйгаа сайжруулсан билээ” гээд газраар явахаар болж одоо 15 дахь аймагтаа ирээд байна. Өчигдөр орой Увс аймгийн иргэд сонгогчидтой уулзалт хийгээд шөнө 12:00 цагт наашаа гарлаа гэж байсан. Өнөө өглөө 07:00 цагт ирчихсэн байж байгаа юм. Арваадхан хоног арав гаруй аймгийг газраар туулж барна гэдэг ихээ эр зориг, сэтгэл зүтгэл юм шүү. Одоо ийншээ алзахгүй ээ. Ардчилсан нам дөрвөн жил засаг барихдаа аймаг, орон нутгийг засмал замаар холбохоор чамгүй ажил өрнүүлсэн. Үүний үр дүнд хамгийн зах нь энд, Тосонцэнгэлд ирээд байна. Хийсэн бүтээсэн юм дээгүүрээ яваад аймгуудаар тойрчихно гэдэг сайхан юм. 1.5 тэрбум ам.доллар босгоод салхинд хийсгэчихлээ, ард түмэнд ачаа үзүүллээ гээд л байсан. Одоо хар л даа. Аймгууд авто замаар холбогдлоо. Асар их эдийн засгийн хэмнэлт хийж, үр өгөөжөө өгч байна. Дарга нар дээгүүр нисээд явчихаж байгаа хойно үүнийг ойлгож танхгүй, олж харайхгүй биз. Тиймдээ ч энэ бол ард түмний зам юмаа” гэв.

МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
90873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн **Б.ӨНӨРТОГТОХ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017



Улс төрийн дөрвөн нам эвтэй Ерөнхийлөгчийг дэмжлээ

Монгол Ардын Намаас Ерөнхийлөгчид нэр дэвшигч Миегэомбын Энхболдыг улс төрийн дөрвөн нам дэмжиж байгаа аж. Монгол Ардын Намын нарийн бичгийн дарга Ц.Бат-Энх, Улс төр, намын байгуулалтын газрын дарга Б.Баярбаатар нар эдгээр намын удирдлагуудтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Тухайлбал, Эх орон намын ерөнхий нарийн бичгийн дарга И.Эрдэнэбаатар, Монголын ардчилсан хөдөлгөөний намын

ерөнхий нарийн бичгийн дарга М.Ганзориг, Хамут Монголын хөдөлмөрийн намын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Одсүрэн, Монголын эмэгтэйчүүдийн үндэсний намын дарга Б.Саранцэцэг нар Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболдын дэвшүүлсэн “Монгол төр-монгол гэр” мөрийн хөтөлбөрийн үзэл баримтлал, “Эвтэй Монгол-Ээлтэй төр” уриаг дэмжиж энэхүү сонгуульд оролдож буйгаа илэрхийллээ. Эдгээр намуудын

удирдлагууд хэлэхдээ “Босго өндөр төрийн тэргүүнээ сонгох сонгуульд төрийн ажлын арвин туршлагатай, бэлтгэгдсэн нэр дэвшигч М.Энхболдыг дэмжиж байна. Түүний дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр бол эв эе, эв нэгдлийг илэрхийлсэн, уриа нь ч мөн төрийн тэргүүнд Үндсэн хуулиар олгосон Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч байх үндсэн үүрэг хариуцлагад нь нийцсэн байгаа учир Ерөнхийлөгчийн сонгуульд бид дэмжиж оролдож байна” гэлээ.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

С.ГАНБААТАР: Би Архангайчуудад итгэж байна

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч С.Ганбаатар Архангай аймагт ажиллалаа. Энэ үеэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч ажилчидтай уулзалт зохион байгуулав. Тэрбээр “Олон жил хүний төлөө Монголын баялагийг гадныханд биш ард түмэндээ хүргэе гэж тэмцэж ирлээ. Үнэнээр явбал үхэр тэргээр туулайг гүйцнэ гэж итгэж зүтгэсэн. Та нар маань тухайн цаг үеүдэд намайг хамгаалж өмгөөлж байсан учраас би өнөөдөр Ерөнхийлөгчид нэр дэвших болоод явж байна. Хүн гэдэг хүч тэнцвэргүй энэ тулаанд итгэдэг хүндээ хамаг зүйлээ ярьдаг юм байна. Би Архангайчуудад

итгэж байна. 13 жил Оюутолгой, Тавантолгой, Дубайн гэрээний луйвруудын талаар ярилаа. Монгол ядууралгүй баян байгаасай гэж хүсч байна. Ингээд тэмцэж ярихаас цаашгүй байна гэдэг үнэхээр хэцүү юм. Гэхдээ Мөнх тэнгэр ивээж хамтдаа Монголоо аврах боломж бидэнд ирлээ. Та бүхэн эх орноо аврахад минь туслаарай” гэж байв. Үүний дараа Архангай аймгийн захаар явж иргэд сонгогчидтойгоо уулзлаа. Монголоо аврах төлөвлөгөөгөө танилцуулсан МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарыг Архангайн сонгогчид дэмжинэ гэдгээ илэрхийлж байв.



МЭДЭЭЛЭЛ

Ирэх мягмар гарагт ойн түймэрт зориулж үүл буудна гэв

Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх ой хээрийн түймэртэй холбогдуулан өчигдөр хэвлэлийн бага хурал хийлээ. Тэрбээр хурлын эхэнд “Говь” компанид гарсан галын талаар мэдээлэл өгсөн юм. Дараа нь улсын хэмжээнд гарч буй ой хээрийн түймрийн тухай мэдээлж, холбогдох хүмүүст үүрэг өгөв. Тухайлбал, энэ сарын 14-ний байдлаар Улаанбаатар хотод 16 удаа, Архангай, Баян-Өлгий, Булган, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймгийн 49 суманд 79 удаа нийт 95 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч 38821.3 га ой, 27687 га хээр, нийт 66508,3 га талбай түймэрт өртөж шатсан гэх харамсалтай мэдээ гарчээ. Энэ оны эхний зургаан сард гарсан ой, хээрийн түймрийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.5 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа аж. Цаг уурын байгууллагаас гаргасан цаг агаарын

урьдчилсан мэдээгээр нийт нутгаар зургадугаар сард хуурайшилт нэмэгдэж ой, хээрийн гал түймрийн эрсдэл ихсэх хандлагатай байгаа Шадар сайд холбогдох албаныханд мэдэгдэл хүргүүлсэн байна. Аймаг нийслэлийн Засаг дарга, аймгийн Онцгой комиссын дарга нарт түймрийн эрсдэл ихтэй бүс нутгуудад хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэг ажиллуулах, урамшуулалт морин эргүүлтийг зохион байгуулах мөн түймэр унтраах ажилд дайчлагдан ажиллаж байгаа алба хаагчдад шаардлагатай хангалтын ажлыг шуурхай зохион байгуулахыг үүрэг болгов. Мөн Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын генерал Т.Бадрал, ЦЕГ-ын дарга, Цагдаагийн хуралдаа Ө.Энхтөр нарт ч үүрэг өгч, шуурхай ажиллахыг санууллаа. Энэ үеэр ЦУОШГ-аас ирэх мягмар гарагт түймэрт зориулж үүл буудна хэмээн мэдээлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭНЮМЖЭЛЭВ

Дугаарын 60 мөр

Монголчууддаа баярлалаа

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт



Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал алдагдчихлаа. Уг нь бол нэг улсаас эдийн засгийн хараат байдал 30 хувиас хэтрэхгүй байх ёстой. Гэтэл бид урд хөршөөсөө 96 хувийн хамааралтай болчихоод байна. Монголоос гарч буй бүх баялаг түүхийгээрээ урд хөрш рүү урсч байгаа. Энэ бол эдийн засгийн тусгаар тогтнол биш. Би үүнтэй тэмцэхийн тулд "Монгол ялна" гэсэн уриаг анд нөхөдтэйгээ ярилцаж байж гаргасан юм. Өнөөдөр бид газрын баялаг руугаа хэт улайран орж байна. Тэр дундаа улстөрчид нам хамаарахгүйгээр гар нийлэн газрын баялгаа гадаадынхантай хамтран цөлмөх боллоо. Газрын баялаг гадагшаа урсч, бид өрөнд орсоор байна. Газрын баялгаа бид тоолж, хурааж, бүртгэж чадахгүй байгаа. Тэр дундаа говийн бүсийн Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь, Баянхонгор гэх зэрэг олон аймаг газрын доорх баялгаа түүхийгээр нь урд хөрш рүү зөөж байна. Энэ байдлыг засахын төлөө ажиллах, зүтгэх цаг болж. Гэхдээ энэ бол АН-ынхны, энэ намаас нэр дэвшиж буй миний л үүрэг гэж бодохгүй байна. Энэ бол Монголоор овоглосон хүн бүрийн үүрэг байх ёстой. Энэ бол ганцхан миний, АН-ынхны үүрэг биш, Монголоо гэсэн хүн бүхний үүрэг

шүү. Одоо л дуугарах хэрэгтэй байна. Нэг улсаас 100 хувь хараат болсны дараа дуугарна гэвэл оройтсон байх болно" хэмээн тайлбарласан юм.

С.Ганбаатар: Монголоо аврах боломж бидэнд ирлээ

Харин Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар Архангай аймагт ажиллажээ. Тус аймгийн иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийх үеэрээ тэрбээр "Олон жил хүний төлөө Монголын баялгийг гадныханд биш ард түмэндээ хүргэж гэж тэмцэж ирлээ. "Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ" гэж итгэж зүтгэсэн. Та нар минь тухайн цаг үед намайг хамгаалж өмгөөлж байсан учраас би өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшээд явж байна. Хүн гэдэг хүч тэнцвэргүй энэ тулаанд итгэдэг хүндээ хамаг зүйлээ ярьдаг юм байна. Би Архангайчуудад итгэж байна. 13 жил Оюутолгой, Тавантолгой, Дубайн гэрээний дуйврын талаар ярилаа. Монгол ядууралгүй баян байгаасай гэж хүсч байна. Ингэж тэмцэж ярихаас цаашгүй байна гэдэг үнэхээр хэцүү юм. Гэхдээ мөнх тэнгэр ивээж Монголоо аврах боломж бидэнд ирлээ. Та бүхэн эх орноо аврахад минь туслаарай" гэсэн юм.

М.Энхболд: Төв аймаг хаягддаг гэдгийг олон жил ярьсан

МАН-аас нэр дэвшигч М.Энхболд Улаанбаатар хотод төрсөн ч Төв аймаг, Баян сумаар овоглох дуртай. Төрсөн нутгийнхантайгаа уулзалт хийхдээ тэрбээр "Та нартайгаа уулзаж, мэргэн сургаалийг тань сонсч, захиа даалгаврыг чинь хүлээн авах, энгүүн сайхан яриа хөөрөө өрнүүлээд буцахад төр засгийн буулга өндөртэй албаны алжаал ядрал тайлагддаг, эрч хүч нэмэгддэг юм. Уул ус, нутаг нугынхан нь нутгийн хүүгээ ямагт дэмжин өндөлзөж байдаг гэдэг. Би ч бас ийм түшиг, хүндлэлийг байнга мэдэрч байдаг. Энэ удаагийн сонгуульд ч гэсэн та нар минь намайг дэмжиж, захыг минь мушгиж суугааг би мэдэж байна. Би та нарынхаа төлөө, Монгол Улсынхаа төлөө хоёргүй сэтгэлээр хичээн зүтгэнэ. Ерөнхий сайд байхдаа эхлүүлсэн Хөшигийн хөндийн нисэх буудал маань ашиглалтад орох хугацаа тун дөхөж байна. Нийслэлийн хаяанд байдаг учраас Төв аймаг хаягддаг гэж олон жилийн турш бид ярьсан. Хөшигийн хөндийн нисэх буудал, түүнийг дагасан шинэ суурилын бус манай аймагт томоохон дэвшил авчирна гэж анхнаасаа бодож, эхлүүлсэн юм" хэмээн аминчхан амлалт өгч, сэтгэгдлээ хуваалцжээ.



газрын баялгаа гадаадынхантай хамтран цөлмөх боллоо. Газрын баялаг гадагшаа урсч, бид өрөнд орсоор байна. Газрын баялгаа бид тоолж, хурааж, бүртгэж чадахгүй байгаа. Тэр дундаа говийн бүсийн Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь, Баянхонгор гэх зэрэг олон аймаг газрын доорх баялгаа түүхийгээр нь урд хөрш рүү зөөж байна. Энэ байдлыг засахын төлөө ажиллах, зүтгэх цаг болж. Гэхдээ энэ бол АН-ынхны, энэ намаас нэр дэвшиж буй миний л үүрэг гэж бодохгүй байна. Энэ бол Монголоор овоглосон хүн бүрийн үүрэг байх ёстой. Энэ бол ганцхан миний, АН-ынхны үүрэг биш, Монголоо гэсэн хүн бүхний үүрэг

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

Г.Доржзодов: Чамайг "Зоригийн хэрэг шиг болгоно шүү" гэж удаа дараа сүрдүүлсэн



Гэрээ зурвийг ГАРТУУЖИИ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

УгхэрэгявдалболсныдарааАН-ындаргаС.Эрдэнэ, тус намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулга, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл нар Завхан аймагт хэвлэлийн хурал зарлан, мэдэгдэл хийв. Энэ үеэр Ардчилсан намын дарга С.Эрдэнэ "60 тэрбумын бичлэг гэдэг нь Монголын нийгэмд маш их аюул учруулсан байж болзошгүй. Өнгөрсөн сонгууль ч энэ схемээр явагдсан байж болзошгүй. Тиймээс хууль хяналтынхан маань түүх та бүхнийг шүүнэ шүү. Тиймээс монгол төрийнхөө хууль тогтоомжийнхоо хүрээнд үйл ажиллагаа явуулаач ээ. Ардчилсан намын 180 мянган гишүүндээ уриалахад Монгол Улсын маань ардчилал хүний эрхэнд аюул учирлаа. Хүн бүр дор бүрэнэ сонор сэрэмжтэй байгаарай. Тиймээс нийт монголчууд минь энэ хууль бус бусармаг зүйлд дуу хоолойгоо нэгтгэж, эв санаагаа илэрхийлнэ үү" гэв. Үүний дараа МАН-ын УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин, Ц.Цогзолмаа, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан болон Хуульзүйн дэд сайд Б.Энхбаяр нар хэвлэлийн бага хурал зарласан юм. Хэвлэлийн хурлаар МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан "Өрсөлдөгчдийн зүгээс сонгуулийн хар технологийг хэрэглэж, өндөр зохион байгуулалттай гүтгэн гүжирдэх асуудал хэрээс хэтэрч байна. Тэр тусмаа АН-ын сонгуулийн штабаас зохион байгуулалттай

нэвтрүүлэг олныг цацаж байна. Орон нутгийн болон УИХ-ын сонгуулиар 60 тэрбум төгрөгийн асуудлыг ил болгосон. Одоо Ерөнхийлөгчийн сонгуулиар гарч ирлээ. Гурван сонгуулиар энэ асуудлыг гаргаж ирлээ. Г.Доржзодов намайг ална гэсэн гэж мэдэгдсэн байна лээ. Гэтэл тийм зүйл болоогүй" гэв. Харин энэхүү хэргийн талаар Хууль зүйн дэд сайд Б.Энхбаяр "Цагдаа иргэн Г.Доржзодовын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтанд авсан байна. Ямар нэгэн баривчлах үйл ажиллагаа хийгдээгүй болно" хэмээн жиргэсэн юм.

Мөн энэ асуудлаар ЦЕГ-аас хэвлэлийн бага хурал зарлаж, ЦЕГ-ын тэргүүн дэд дарга П.Батбаатар тайлбар хийлээ. Хэрэг явдлын талаар "Эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдсанаас хойш Г.Доржзодов нь хоёр хоног "Иргэний хөдөлгөөний тэргүүн" Г.Баасангийн гэрт байрлаж, тэндээсээ янз бүрийн мэдээлэл нийтэлж ард иргэдийг төөрөгдүүлсэн. Сүүлийн дөрөв хоногт нь УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэлийн гэрт байрлаж, худал мэдээ мэдээлэл зохион байгуулалттай цацсан нь тогтоогдоод байна. Г.Доржзодовыг нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэхээс эсэргүүцэж байгаа хүмүүс амь бие, эрүүл мэндэд нь халдах байдал гарч болзошгүй гэх мэдээлэл бодитойгоор авагдсан болохоор цагдаагийн байгууллага хамгаалалтад авах нь зөв гэж үзсэн. Цагдаагийн байгууллага хуулиараа ЭБША-ны оролцогчдыг хамгаалалт авах үүрэгтэй" хэмээн тайлбарлалаа.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН БУЛАГ АМРАЛТЫН ГАЗАР АЖИЛЛАХ ТОГООЧ ШАЛГАРУУЛЖ АВНА

Тавигдах шаардлага:

- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологич мэргэжилтэй
- Тогоочийн зэрэгтэй байх
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтанд хамрагдсан
- Нийтийн хоолны салбарт мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажиллаж байсан туршлагатай
- Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай, харилцааны соёлтой
- Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх чадвартай

Бүрдүүлэх материал:

- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй/ МҮОНРТ-ийн ажилтны анкетийг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллага, хүмүүсийн тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны зургаадугаар сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг Хувьсгалчдын зам-3 Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз Хүний нөөцийн алба Утас: 325802

МЭДЭЭЛЭЛ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Цэцэрлэгийн барилга 150 ор /БГД, 20 дугаар хороо, 47 дугаар цэцэрлэг/-ын ажил

Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0179

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Цэцэрлэгийн барилга 150 ор /БГД, 20 дугаар хороо, 47 дугаар цэцэрлэг/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2015, 2016/

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жилд /2015, 2016 он/

доод тал нь нэг удаа төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

Барилга, хот байгуулалтын яамны:

- 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)

- 1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

- 1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

(10 кВ хүртэл)

Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КНП/, автоматикийн зураг төсөл

- 1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

Барилга, хот байгуулалтын яамны:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

- 2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өргөт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар/

- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 20,457,000 /хорин сая дөрвөн зуун тавин долоон мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна. Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 13 цаг 00 минутас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшдуулан тендерийг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 13 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот хурлын өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодны давуу эрх тооцно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,

Утас: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 100 ор /СХД, 12 дугаар хороо, 105 дугаар цэцэрлэг/-ийн ажил

Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0181

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 100 ор /СХД, 12 дугаар хороо, 105 дугаар цэцэрлэг/-ийн ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2015, 2016/

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жилд /2015, 2016 он/ доод тал нь нэг удаа төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

Барилга, хот байгуулалтын яамны:

- 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)

- 1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

- 1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

(10 кВ хүртэл)

Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КНП/, автоматикийн зураг төсөл

- 1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

Барилга, хот байгуулалтын яамны:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

- 2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өргөт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар/

- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 7,364,000 /долоон сая гурван зуун жаран дөрвөн мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна. Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минутас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшдуулан тендерийг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот хурлын өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодны давуу эрх тооцно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар,

Утас: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ,
АЖ АХУЙН НЭГЖИЙН
АНХААРАЛД

Тус сонин 2017 оны 06 сарын 15-ны өдрийн тус сонин №116 (4730) дугаарын 6, 7 дугаар нүүрт нийтлэгдсэн дараах тендерийн урилгын санал хүлээн авах хугацааг залруулж байна. Үүнэ:

“БУСАД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ”-ын зөвлөх үйлчилгээний тухай зарлалын “Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү” гэсэн хэсгийг **“Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 15:00 цагийн дотор ирүүлнэ үү”** хэмээн залруулж байна.

“ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ” ажлын зөвлөх үйлчилгээний тухай зарлалын “Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү” гэсэн хэсгийг **“Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү”** хэмээн залруулж байна.

“НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН САЛБАРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ” Багц 1-45 зөвлөх үйлчилгээний тухай зарлалын

-Багц 20 : “СБД-ийн 16 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах” гэснийг “Багц 20: БГД-ийн 16 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах” гэж,

-Багц 28: “СХД-ийн 55 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах” гэснийг “СХД-ийн 55 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах” гэж,

-Багц 37: “СБД-ийн 12 дугаар хороонд баригдах сургуулийн барилгын зураг төсөв боловсруулах” гэснийг “ХУД-ийн 73 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах” гэж,

-Багц 40: “БГД-ийн 13 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах” гэснийг “БЗД-ийн 62 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах” гэж тус тус залруулж байна. Мөн Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү” гэсэн хэсгийг “Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 11:00 цагийн дотор ирүүлнэ үү” хэмээн залруулж байна.

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР



МУБИС-г багш шалгаруулж авна

БАГШИЙН СУРГУУЛЬ:

- Сурган сэтгэл судлалын багш -1
- Хөгжим арга зүйн багш -2

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ:

- Сэтгэл судлалын багш -1

УРЛАГ, БИЕЙН ТАМИРЫН
СУРГУУЛЬ:

- Хөгжмийн онолын /гармони/ багш-1
- Найрал дууны багш -1
- Сагсан бөмбөгийн мэргэжлийн багш-1
тус тус шалгаруулж авна.

ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Монгол улсын төрийн болон гадаадын их дээд сургуулиудыг магистр болон түүнээс дээш зэрэгтэй төгссөн, ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулиудад багшилж байсан туршлагатай, судалгааны арга зүй эзэмшсэн, гадаад хэл (англи, орос, болон бусад), сурган хүмүүжүүлэх ухаан, боловсрол судлалын зохих мэдлэгтэй, мэдээлэл харилцааны технологийн хэрэглээний чадвар эзэмшсэн, багаар ажиллах чадвартай, оюутнуудтай харилцах эв дүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролын шинэчлэлд нээлттэй, тогтвор суурьшигтай ажиллах, багшийн ёс зүйг сахидаг байх.

Бүртгэл: 2017 оны 06 дугаар сарын 19-23-ныг дуустал МУБИС-ийн 1-р байрны /хуучнаар А байрны/ 108 тоотод явагдана.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- CV монгол хэлээр
- Бакалавр, магистр докторын дипломын баталгаажуулсан хуулбар
- Төрийн албан хаагчийн анкет
- Ажил байдлын тодорхойлолт
- Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- Цээж зураг 3 хувь /3*4/
- Нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтэрийн хуулбар
- Шалгалтын хураамж 20.000 төгрөг тус тус авч ирнэ үү

ШАЛГАЛТ: 2017 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд дараах чиглэлээр явагдана.

ҮҮнд:

1 Эхний ярилцлага
2 Мэргэжлийн шалгалт
3 Гадаад хэл /Англи, орос болон бусад хэл/
4 Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний чадвар
5 Боловсрол судлалын орчин үеийн асуудлууд
6 Нэгдсэн ярилцлага

Жич: Тухайн шалгалтандаа тэнцээгүй ажил горилогчийг дараагийн шатны шалгалтад оролцуулахгүй бөгөөд хураамжийг буцаан олгохгүй болохыг анхаарна уу

Холбогдох утас: 311547, 99957309
Хөтөлбөрийн нэгдсэн алба

ОНЦЛОХ ХУУДАС

Өүй үү өүй ауй?

Дарханчуудын ДААЛГАВРЫГ ӨВӨРТӨЛСӨН гурав



...УИХ дахь ангийн анд нь ч шинэковдож “Н.Золжаргалын тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан, УИХ-ын гишүүн Б.Жавхлангийн буруутай эсэхийг хуулийн байгууллагаар шалгуулна” хэмээн дарь дээр давс нэмж орхисон. Төв банкны хуулийн дагуу төв банкны үйл ажиллагааны хяналт шалгалтыг хариуцаж байсны хувьд буруудахгүй байх нөхцөл үгүй...

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Цианит натритын “хор”-ыг ч ажиггүй давсан түшээ

Уг нь мань хүн Завхан аймгийн Тосонцэнгэлийн гаралтай ч эдүгээ Дарханы Д.Хаянхярваа хэмээн овоглогдож буй. Сайн хийгээд саар зүйлийн алинд ч. Москвагийн их сургуулийг Барилгын инженер эдийн засагч мэргэжлээр дүүргэсэн түүнийг Дархан хотын Угсармал барилга үйлдвэрлэлийн нэгдэлд эдийн засагчаар томилгогдсоноор тэндэхийн хүн болсон хэрэг. Д.Хаянхярваагийн намтрын хуудсыг эргүүлэх аваас хэн хүний сонирхлыг тэтгэлээ татаад байхгүй ч хашиж байсан албан тушаал дээрээ байнга өсч дэвжсэн байх юм. Харин түүний мөнхийн өрсөлдөгч нар нь эртэй сайндаа биш ээ, Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн он жилүүдэд чадалтай залуус ганзаганд явж, Хаянхярваа мэтийн улс бууриа сахиж үлдсэн юм. Цаг үе түүнд ийм боломжийг олгосон гэх үү дээ хэмээн үл тоох байдлыг үзүүлэх юм билээ. Гэхдээ Д.Хаянхярваагийн хувьд ямар байлаа ч хожсон. Төрийн

алба түүнд буян хийгээ харамгүй хайрласан. Төрд зүтгэснийхээ буянаар өдий зэрэгтэй яваа болов уу. Ганзага үүрээд гүйсэн бол төр түших хэмжээнд боловсроо ч үгүй юу хэн мэдлээ. Одоо түүний юуг ч өөчлөөд нэмэргүй. Галт тэрэг хэдийнэ хөдөлсөн. Д.Хаянхярваа гэх хувь хүний зан төрх, амьдрал ахуй хэрхэн яаж өөрчлөгдсөнийг зөвхөн ойр дотныхон л хэлэх байх. Учир нь тэр эдүгээ Монголын төрд ч, МАН-д ч нэр нөлөө бүхий хүн болсон. Энхрий хайрт намаа улаан хамгаалагч шиг цээжээрээ мөн ч олон удаа хамгаалсан даа. Аргагүй байдалд орохоороо мань хүнийг “сумлаад” тавьчихдаг байж мэднэ. Төрийн ордонд зарлагдсан хэвлэлийн хурлын хойморт тэр л суучихсан, хэл амаа билүүдэж байдаг юм. Ер нь хэлэмгий доломгой нэгэн л дээ. Ямар ч үед өөрийгөө хамгаалаад гарах нь бий. Өнөө алдартай цианит натритай холбоотой асуудал Хонгор суманд дэгдэж, хоёр сонгууль дамжин дуулиан болоход Д.Хаянхярваа түүнийг даваад л гарсан. Тэр үед мань хүн Дархан-Уул аймгийн Засаг дарга байсан. УИХ-д нэрлэвхийд ч бас л түүгээр нь ороож байлаа. Энэ бүх хэл ам түүнийг аймагтаа бус түмэнд танил болгож орхисон юм. Улстөрчдөд хар пиар заримдаа хэрэг болдгийн жишээ эрхэм гишүүндээрхарагдсан. Харин одоо гишүүнд ямар ч пиар хэрэггүй. Намынх нь алдаа эндэгдэл түүнийг нэр хүндийг өндрөөс өндөрт өргөдөг гэж хэлж болно. Бас тоо. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсөв, төсвийн тодотгол ярьж эхлэх үед мань эрийн онгод орж, төсвийн асуудлаар асуулга тавьсан гишүүдийн амыг хэдхэн тоо хэлээд л нам таглаж орхидог. Төсвийн байнгын хорооны дарга, Сангийн сайд байхдаа ч ялгаагүй. Цэжнийхээ гүнд Сангийн сайд асан Ч.Улааныг давжгарах юмшүү гэх бодол байхыг үгүйсгэхгүй. Ийм нэг төрийн түшээ Дархан-Уул аймгийн дөрөвдүгээр тойргийн иргэд гурвантаа сууж буй. Түүнийг тойрогтоо сайн ажилладаг, тойргоо ойр ойрхон “усалдаг” түшээ хэмээгддэг. Төсвийн байнгын хороон дарга, Сангийн сайдаар ажиллаж байсан хүний хувьд тойрог руугаа, аймаг руугаа төсөв мөнгө

хуваарилуулах, хөрөнгө татах тухайд тэр хөдлөхгүй юм бол хэн гүйх юм. Гэвч амьдрал дээр аймагт нь нүд баясгаж, сэтгэл хөдөлгөх бүтээн байгуулалт тийм ч олон харагддаггүй. Дорноговь шиг, Сүхбаатар, Архангай шиг танигдахгүй болтлоо өөрчлөгдөөгүй, өнгөрсөн найман жилийн хугацаанд. Хүн ам олонтой болоод хуваариуулсан төсөв, хөрөнгө оруулалт нь иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулагдаад нүдэнд харагдахгүй байшин барилга болж чаддаггүй байхыг ч үгүйсгэх аргагүй. Дарханчуудын хувьд ажлын байрны хомсдол мөнхийн сэдэв нь. Уг нь бусад аймгийг бодвол хөгжих боломж асар их. Агаараас бусад бүх дэд бүтэц бий. Дээр нь манай улсын барилгын материалын томоохон үйлдвэрүүд тэнд л төвлөрсөн. Тэднээс хэд нь ажиллаж, улсын эдийн засагт нэмэр нөөлөг болж байгаа талаар эрхэм төрийн түшээ маань тэгж байгаад ард түмэндээ тайлагнах биз. Дашрамд өгүүлэхэд, Д.Хаянхярваа гишүүн УИХ дахь тэрбумтнуудын тоонд багтахгүй ч хоосонгүй нэгэн. Жилийнх нь орлого 22 сая 727 мянган төгрөг. Хувьдаа нэг орон сууцтай. “Wolkswagen Tiguan”, “Land cruiser” маркын суудлын удирдах ажилтнууд л нэрийг нь дуулсан, зарим нь ганц хоёр уулзсан байхаас цаашгүй. Улстөрчийн хувьд ч проо шинэ хүн. Гэхдээ нөгөөдүүдээ бодвол амбиц сайтай. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороон дээр хэлсэн үг, гаргасан санаа, байр суурь, санаачилсан хуулийн төсөл, орж ажилласан ажлын хэсгийн дүгнэлт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага зэргээ вэб хуудсандаа

Амбиц сайтай Б.Жавхлан

Дархан-Уул аймаг гурван мандаттай. Нэг мандатын эзэн нь Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч асан Б.Жавхлан. Эдүгээ УИХ-ын гишүүн гэж тодотгож өгөх ёстой. Энэ эрхмийг таних хүн тун цөөн. Банк санхүүгийн салбарын удирдах ажилтнууд л нэрийг нь дуулсан, зарим нь ганц хоёр уулзсан байхаас цаашгүй. Улстөрчийн хувьд ч проо шинэ хүн. Гэхдээ нөгөөдүүдээ бодвол амбиц сайтай. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороон дээр хэлсэн үг, гаргасан санаа, байр суурь, санаачилсан хуулийн төсөл, орж ажилласан ажлын хэсгийн дүгнэлт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага зэргээ вэб хуудсандаа

онсарөдөр, цаг минуттай оруулсан зэргээс нь харж болохоор. Тэгсэн атлаа хөрөнгийнхээ хэмжээг огт дурдаагүй байх юм. Мэдээллийн хэрэгсэлээ ч хайгаад олсонгүй. Мань хашир тэр тухай өгүүлэхгүй байхыг хүссэн бололтой. Нөгөөтэйгүүр, УИХ-ын гишүүн, Нутгийн удирдлагын дэд хорооны дарга Б.Жавхлан гэж хэн бэ гэдгийг нь хэлэхэд арай эрт байна. Тооны хичээлд сайн гэж хэлүүлж явсан шигээ лав биш байх. Хэлсэн үг, хийсэн үйлдлээсээ буцаж байгаа байдлаас нь ийн дүгнэсэн хэрэг. Энэ нь нийгэмд өнөөдөр дуулиан тариад байгаа Монголбанкны ерөнхийлөгч асан Н.Золжаргалтай холбоотой асуудлаас үүдэлтэй. Монгол Улсын эдийн засагт эдүгээ нүүрлэсэн хямралын гол шалтгааныг Монголбанкнаас хэрэгжүүлсэн 2012-2016 оны алдаатай бодлого гэх дүгнэлтийг УИХ-ын шинэхэн гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг гаргаж, тухайн үед Ерөнхийлөгчөөр нь ажиллаж байсан Н.Золжаргалыг буруутгаад байгаа. Тодруулбал, Засгийн газраас үүрэг чиглэл болгосны дагуу “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-тэй холбоотой асуудал. Гэвч УИХ дахь АН-ын бүлгээс хийсэн мэдэгдлээр бол уг асуудалд Н.Золжаргал ганцаар буруудах ёсгүй. Тухайн үед түүнтэй нэг баг болов ажиллаж байсан Б.Жавхлан ч бас буруудах учиртай санагдана. Эл асуудлыг анхааралтай ажиглаж байгаа нийгэмд мань хүн өөрийнхөө хэн бэ гэдгийг “Уг асуудалтад хамаагүй. Би зөвхөн Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу ажилласан” гэх утга бүхий зүйлийг хэлж, өөрийн гэх толгойгүй явдгаа харуулж орхисон. УИХ дахь ангийн анд нь ч шинэковдож “Н.Золжаргалын тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан, УИХ-ын гишүүн Б.Жавхлангийн буруутай эсэхийг хуулийн байгууллагаар шалгуулна” хэмээн дарь дээр давс нэмж орхисон. Төв банкны хуулийн дагуу төв банкны үйл ажиллагааны хяналт шалгалтыг хариуцаж байсны хувьд буруудахгүй байх нөхцөл үгүй. Үнэн хэрэгтээ энэ л хөтөлбөрийн буянаар олон зуун хүн ажлын байраа хадгалан үлдэж чадсан төдийгүй эзэлийн ч болов орох оронтой болсон билээ. Хэргийн

учир “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”, Н.Золжаргалыг буруутгахдаа гол биш чухам тэр үед Б.Жавхлан эр хүн шиг загнасан бол өндөр оноо авах байсан юм, ард түмнээсээ. Нөгөөтэйгүүр, Б.Жавхлан эдийн засагчийн хувьд хэнд ч гологдохооргүй нэгэн гэдгийг түүний хашиж байсан албан тушаалууд гэрчлэх байх. Намтрыг нь сонирхох аваас банкны салбар л түүнийг өөд татаж, энэ дайны явуулж байгаа гэж дүгнэж болох байх. Тойрогтоо хэр сайн ажилладаг тухайд магтчихад гэмгүй. Залуу хүн болоод тэр үү цаг үеийг мэдэрдэг талаараа нөгөө хоёроосоо илүү юм билээ. Хөгшид, хүүхдэд нааштай хандан тэдний үгийг сонсдог талаар дарханчууд ам сайтай байдгийг энд онцлон тэмдэглэх нь зөв байх. Ганцхан жишээ дурдахад, ЕБС-ийн элсэлтийн ерөнхий шалгалт болж буйтай холбогдуулан энэ жил сургууль төгч байгаа хүүхдүүдэд зориулан математик, англи хэлний сургалтыг орон нутагтаа үнэгүйгээр, өөрөөр хэлбэл хувиасаа хөрөнгө гарган зохион байгуулсан нь сонгогчдын төдийгүй хүүхэд залуучуудын талархлыг хүлээсэн арга хэмжээ болжээ.

Тал алддаггүй төрийн түшээ Б.Баттөмөр

Тэрбээр ТЕГ-ын даргаар ажиллаж байсан нэгэн. Уг албан тушаалд гэнэт л томилогдсон. Улстөрч болох зам нь эндээс эхтэй. ТЕГ-ын даргаар ажиллаж байхдаа элдэв хэл аманд өртөж, нэр төрөө сэвтүүлээгүй ч нийгэмд тэтгэлээ танигдаагүй нэгэн. Намтарт нь зөвхөн Татварын ерөнхий газрын даргаар 2012-2016 онд, УИХ-ын гишүүнээр 2016 онд сонгогдсон гэсэн хоёр зүйл л тэмдэглэгдсэн байна лээ. Дархан-Уул аймагт ямар буян үйлдсэн болоод УИХ-д нэр дэвшиж сонгогдсоныг нь хэн ч хэлж чадахгүй. Шулуухан хэлэхэд, МАН-ын бор халзан хонинуудын нэг. Насны хувьд ч залуудаа орохгүй. Гэхдээ тэр аль ч төрд тал алдаж үзээгүй хүн юм билээ. УИХ-ын 2012 оны сонгуулийн үр дүнд АН засгийн эрхийг барьж, жам ёсоор халаа сэлгээг хайр найргүй хийхэд

Татварын ерөнхий газрын дарга Б.Баттөмөрийг дайралгүй тойроод гарсан тухай тухайн үед хэвлэлээр шуугиж байв. Түүнийг өдий өндөрлөгт анд нар нь л чирсэн гэх яриа байдаг. Нэг хэсэг Сангийн сайд асан Ч.Улаантай нэлээн сүжирсэн юмдаг. Улс төрийн хоёр том хүчний аль алинд нь дээгүүр алба хашдаг найзтай түүнд хүмүүс найман жил ажилласан нэгэн. Тийн ажиллахдаа гаалийн газрыг цахимжуулж амжсан нь нэртөрийг нь өндөрт өргөсөн гэж хэлж болно. Монгол Улсын төсвийн дийлэнх хувийг бүрдүүлдэг Татварын Ерөнхий Газрын даргаар ажиллах хугацаандаа Монголын нэр нөлөө бүхий компаниудад хувьцаа эзэмшиж амжсан байх юм. Тухайлбал, хөрөнгө оруулгын мэдүүлэгтээ дурьдсанаар, “Ойн бирж” ХХК, “Жой Эм ойл” ХХК, “Мондем” ХХК, “Тэс петролиум” ХХК, “Сэлэнгэ петрол”, “Жаргалант төв” ХК, “Монгол Эд импекс” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Монгол шевро” ХК, “Хөх ган” ХК-ийг нэрлэж болно. Мөн тэрбээр жилийнхээ орлогыг 387 сая 100 мянган төгрөг мэдүүлдээ. Харин хадгалмаж нь хоёр сая 57 мянган төгрөг. Хувьдаа хоёр орон сууцтай атлаа машингүй юм байна. УИХ-ын гишүүн Б.Баттөмөр боловсролын тухайд ангийнхаасаа тохой илүү. Эдийн засгийн ухааны доктор. Сүүлийн үед эдийн засгийн циркуляр гэдгээр амьсгалж, Монголын эдийн засагт нутагшуулахаар зүтгэж буй. Эдийн засагт ч иргэн хүний чихэнд содон дуулдаж мэдэх эл нэр томьёо нь эргэлтийн шугаман бус эдийн засаг гэсэн үг аж. Түүний тайлбарлаж байгаагаар, Монгол Улс үүнд шилжсэнээр бизнесийн шинэ загвар орж, өрсөлдөх чадвар тэр хэрээр нэмэгдэх гэнэ. Тэгэхээр толгойдоо Дархан-Уул аймгийн бизнесийн хөгжлийн чиг хандлага хэдийнэ боловруулсан байж таарна. Тойргоо эргэдэг, иргэд сонгогчидтойгоо уулздаг, үгийг нь сонсдог, ажил хэрэг болгодог тухайд одоогоор хэлэх зүйл алга. УИХ-д нэг л удаа сонгогдсон бол болно гээд хэргээ бүтээчихээд нүүрээ бууруулдаг хүний нэг биш байгаагаар хэмээе дээ.

МЭДЭЭЛЭЛ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 дугаар сарын 16

Тендер шалгаруулалтын нэр: **Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн эмнэлгийн барилгын дээвэр, гадна талын их засварын ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: НДХААА-2017/А-07

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба эрх бүхий тендерт оролцогчдоос **“Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн эмнэлгийн барилгын дээвэр, гадна талын их засварын ажил”**-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **100’000 төгрөгөөр** худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 аль нэг онд 50.0 сая төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **50.0 сая төгрөгөөс багагүй байх.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2015, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онд 80.0 сая төгрөгөөс багагүй байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **“Шаардлагатай”**
Барилга, хот байгуулалтын яамны 2.1.1 – Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилтын тусгай зөвшөөрөлтэй байх ба эсвэл үүнээс давсан нөхцлийг хангасан тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **3’152’000 /гурван сая нэг зуун тавин хоёр мянган/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 15 цаг 00 минутаас**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 15 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **“Үгүй”**
Дотоодны давуу эрх тооцох эсэх: **“Үгүй”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017 оны 06 дугаар сарын 16

Тендер шалгаруулалтын нэр: **Налайх дүүргийн Хангамж үйлчилгээний төвд гурил, гурилан бүтээгдэхүүн болон бусад хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: НДХААА-2017/Б-13

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба эрх бүхий тендерт оролцогчдоос **Налайх дүүргийн Хангамж үйлчилгээний төвд гурил, гурилан бүтээгдэхүүн болон бусад хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх** –ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50’000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк **100200455009** тоот дансанд тушаана.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онд дундажаар тхуайн оролцож буй багцын дүнгийн 20 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тухайн оролцож буй багцын дүнгийн 30 хувиас багагүй байх шаардлагатай.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 оны санхүүгийн аудитлагдсан тайлан.**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Тухайн оролцож буй багцын дүнгийн 30 хувиас багагүй байх.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **“Шаардлагатай”**

Тендерийн хамт Багц.1- 635’000, Багц.2-570’000, Багц.3-1’820’000, Багц.4-365’000, Багц.5-795’000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 40 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **“Үгүй”**
Дотоодны давуу эрх тооцох эсэх: **“Үгүй”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн нэгдсэн эмнэлгийн барилгын дээвэр, гадна талын их засвар**
Тендер шалгаруулалтын дугаар: НДХААА-2017/А-06

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн нэгдсэн эмнэлгийн барилгын дээвэр, гадна талын их засварын ажил**–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **100 000 төгрөгөөр** худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудад дор хаяж нэг удаа тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай.**

Тендерийн хамт 2 700 000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 11:00 цаг**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн, 11:40 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**
Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2 хороо, Хуульчдын гудамж, Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын байр, 1 давхар, Худалдан авах ажиллагааны алба

Утас-70232788, www.nalaikh-tender.mn

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР ШАЛГАРУУЛЖ АВНА

Тавигдах шаардлага:

- Маркетинг менежментийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Маркетингийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай, судалгааны ажил хийж байсан
- Англи хэлний ярианы болон бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй
- Маркетингийн судалгаа, шинжилгээ хийх, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнд анализ хийх чадвартай
- Шинийг эрэлхийлэгч, санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй
- Удирдан зохион байгуулах чадвартай
- Харицлагын өндөр соёлтой

Бүрдүүлэх материал:

- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын “Бусад” гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
 - Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
 - Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
 - Урьд ажиллаж байсан байгууллага, хүмүүсийн тодорхойлолт
 - 3 хувь цээж зураг
 - Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны зургадугаар сарын 21-ний өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Хүний нөөцийн алба, Утас: 11 325802
Цахим хуудас: www.mnb.mn

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[**Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар**] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [**Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын сургуулийн барилгын сантехникын засвар**]–ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-дхандаж тендерийн бичиг баримтыг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө **50000 /тавин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг [**2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 15 цаг 00 минут**]-аас өмнө [**Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д нэвтрэн орж тендерийн материалаа/pdfфайл/ цахим хэлбэрээр**] ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [**2017 оны 06 дугаар сарын 23**]-ны өдрийн [**15 цаг 30 минут**]-т нээнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:96510404, 70518123)

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 3 давхар 306 тоот, Орон нутгийн өмчийн газар, ахлах мэргэжилтэн Ч.Батболд, утас 96510404

ЦАГ ҮЕ

ТАНД ДУУЛГАХАД

Б.ЭРХЭС

Түрүү булчирхайн өвчлөл залуужиж байна гэсэн хар лэдээ түгээд нэлээдгүй хугацааг ардаа орхиж байна. Эмч мэргэжилтнүүдийн олон жилийн судалгаанаас харахад түрүү булчирхайн үрэвсэл нь 20-40 насанд элбэг тохиолддог бол түрүү булчирхайн хавдар нь 50-60 насанд тохиолддог байна. Олон эрчүүдийг эрүүлжүүлж, шаналгаа зовиураас нь салгаж байна гэсэн таатай мэдээллийн төрөөр бид "Unicity" компанийг зорин очиж эрүүл мэндийн зөвлөх С.Батцэцэгтэй уулзаж ярилцлаа.

-Танд энэ өдрийн мэнд хүргэе. Манай уншигчдад компанийнхаа талаар танилцуулахгүй юу? -Сайн байцгаана уу? Та сонинг сонгон уншиж байгаа нийт



Улаанбаатарт:

Weather forecast for Ulaanbaatar: Margash, Odor 21, Shono 11, Hogoodor, Odor 23, Shono 8.



ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал: Идээ ундаа илбэг олддоно Наран ургах/ шигэх: 04:59-20:50



ЭРЧҮҮД ХОЁР ДАХЬ ЗҮРХЭНДЭЭ САНАА ЗОВОЛТГҮЙ БОЛЛОО

уншигчиддаа энэ өдрийн мэндийг хүргэе. Юнисити компани нь 1903 онд АНУ-ын Юта мужид байгуулагдсан. Дэлхийн анхны "Эмийн сан" 25000 эмийн сангай анх байгуулагдаж байсан. Тус компани нь түүхийн 114 жилийн хугацаанд витамин С-г зөгийн тоосонцороос, Омега 3-г загасны тосноос, эмийн капсулыг цагаан будаагаар хийх гэх мэт нээлтүүдийг хийсэн бөгөөд "Юнисити" компанид 40 гаруй нобелийн шагналт эрдэмтэн, эмч нар ажилладаг. Манай улсад орж ирээд нэлээдгүй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд олон мянган хүн бүтээгдэхүүнийг маань хэрэглэж үр дүнг нь үзээд байна. Манай компанийн бүтээгдэхүүн нь АНУ-ын эм, эмнэлзүйн захиргааны хяналтан дор гаргадаг Physician's Desk Reference (Эмч нарын ширээний зөвлөх) номд 16 бүтээл нь орсон. Бүтээгдэхүүнүүд нь АНУ-ын зүрхний болон чихрийн шижингийн үндэсний зөвлөлүүдээр баталгаажуулсан байдаг юм. "Unicity" компани нь АНУ-ын ТОП-100 компанийн нэг нь юм. Юта мужийн №1 компани. Дэлхийд алдартай "koshel" лабораторийн олгодог байгалийн цэвэр бүтээгдэхүүний чанарын гэрчилгээтэй.

үр дүн үзүүлдэг нь хэрэглэгчдийн үр дүнгээс харагдаж байна. Завгүй амьдралын хэмнэл, ажлын ачаалал зэргээс шалтгаалж сүүлийн үед эрчүүд бэлгийн чадавхи буурах асуудалтай тулгарах болсон. Энэ төрлийн бүх асуудлыг манай компанийн байгалийн бэлдмэл болох "RENEW for men" 100 хувь шийдэж байгаа. Энэ мэт асуудалтай, сэтгэл хангалуун бус яваа бол та бидэнтэй холбогдоорой гэж хэлсэе.

Түрүү булчирхайгаа мэс засалгүйгээр эмчлэх боломжтой

-Эрчүүдийн хоёр дахь зүрх бол "түрүү булчирхай" гэдэг шүү дээ. Эрчүүдийн түрүү булчирхайн өвчлөл маш их болжээ?

-Тийм ээ. Түрүү булчирхай бол эрчүүдийн хувьд үнэхээр чухал эрхтэн. Түрүү булчирхай нь бага аарцагны хөндийд, байрласан манжин хэлбэртэй, булчинлаг болон булчирхайлаг эдээс тогтсон эрхтэн юм. Эрчүүдийн дунд сүүлийн жилүүдэд түрүү булчирхайн үрэвсэл, томролт,шохойжилт, хавдар зэрэг өвчлөл маш их болсон байна. Энэ нь эрчүүдийн архи дарс, тамхи, эмийн зохисгүй хэрэглээтэй холбоотой байгаа. Цаашлаад, амьдралын буруу хэвшил, бэлгийн замын халдварт өвчин, цайр, селен эрдсийн дутагдал, хоол хүнснээс хангалттай шинж тэмдэг авч чадахгүй байх, болон бүдүүн нарийн гэдэсний бохирдол шингэгч гэх мэт олон хүчин зүйл нөлөөлж байна.

-Түрүү булчирхайн өвчлөл илрэх шинж тэмдгийн хувьд ямар байдаг бол. Эрчүүд тун хэнэггүй улс. Тэр ч утгаараа өвдөж байсан ч юуных вэ гэдгээ тоохгүй явах нь түгээмэл шүү дээ?

-Эр нь бол тодорхой шинж тэмдэг илэрдэг. Үүнийг оношлуулахгүй яваад байвал олон л хүндэрнэ. Тухайлбал, цавь руу хатгаж, янгинаж өвдөнө. Шөнө олон удаа босч шээх, ойрхон ойрхон шээх, Шээс цустай гарах, шээсний дараа шээс үлдсэн мэт санагдах, Шээхэд өвдөх, шээс удаан тасалдаж, дүлүүлж гарах, Ууцаар өвдөх гэх мэт зовиур илэрдэг. Эрчүүдийн бэлгийн чадавх буурах зэрэг ноцтой шинж тэмдэг илэрч эхэлвэл шууд эмчид хандах, онош тодорхой болсон үед 100 хувь ургамлын гаралтай манай бүтээгдэхүүнээр эмчлэх боломжтой юм. Дээрх шинж тэмдгээс 2-3 илэрвэл шууд эмчид хандаарай. Мөн манайх сүүлийн үеийн дэвшилтэд тоног төхөөрөмжөөр бүтэн биеийн болон түрүү булчирхайн оношилгоог хямд хийж байгаа.

-Бүтээгдэхүүнийхээ талаар танилцуулаач. Эрчүүдийн толгойн өвчин болдог түрүү булчирхайн өвчлөлийг бүрэн дүүрэн эмчилдэг гэдэг утгаараа тун ч ам сайтай, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өндөр байдаг юм билээ?

-Тэгэлгүй явах. Манай компанийн түрүү булчирхайн доктор хэмээн нэрлэгддэг "PROSTATE TLC" нь миний өмнө хэлсэн өвчин зовиурыг цогцоор нь эмчилдэг. Түрүү булчирхайн томролт, үрэвсэл, шохойжилтыг хайлуулах ургамлын гаралтай антибиотик мэт үйлчилгээтэй. Түрүү булчирхайн сувгууд болон шээсний замыг эрүүлжүүлнэ. Мөн давсаг бөөрний үрэвслээс гадна үе мөчний үрэвслийг ч дардаг цогц үйлчилгээтэй бүтээгдэхүүн. Түрүү булчирхайн хортой хоргүй хавдрын үед мөн манай компанийн зарагддаг SIG гэх бүтээгдэхүүнтэй хавсран хэрэглэхэд илүү өндөр

Унхээр гайхалтай үр дүнгүүд гарчээ. Нэгэнт танайхыг зорин ирсэн болохоор танай цэвэрлэгээний бүтээгдэхүүний талаар асуухгүй өнгөрч чадахгүй нь ээ. Танай цэвэрлэгээний бүтээгдэхүүнийг хүмүүс хэдийнээ мэддэг болжээ. Таргалалт яах аргагүй Монгол Улсын хувьд анхаарал татах асуудал болж байна. Бүр дэлхийд дээгүүрт бичигдэж байна?

-Тийм шүү. Манайх шиг гайхалтай цэвэрлэгээний бүтээгдэхүүн хаана ч байхгүй шүү гэж хэлмээр байна. Амьдралын буруу хэвшилээс болж олон хүмүүс таргалалт өртөж байна. Мөн өтгөн хатагт бол асуудал дагуулах хэмжээнд хүрчихсэн. Тэгвэл өтгөн хатагтыг мартаж боломжийг бид олгодог. Өтгөн хатагт үүсэх гол шалтгаанууд нь ус бага уух, хөдөлгөөний дутагдал, эслэг хүнс идэхгүй байх, аминдэм эрдсээ авахгүй байх, уураглаг хүнс ихээр идэх, хэт орой хооллох гэх мэт ордог. Хүний бүдүүн гэдсэнд 5-25 кг баас шавдас хадгалагдан янз бүрийн бактери, вирус, микроб, паразитуудын үржих таатай орчинг бүрдүүлэн хүний бие организмг хордуулж, өвчин үүсгэдэг. Монголчуудын хувьд гэдсээрээ бүдүүн байх хамгийн гол шалтгаан нь эслэг хүнс буюу лууван, чавга, чангаанз, алим гэх мэт шир шир хийсэн жимс, ногоо идэхгүй байгаатай холбоотой бөгөөд өдөр тутамдаа цэвэрлэгээ хийхгүй байгаа юм. ДЭМБ-аас зарласан хүний хоногт авах эслэгийн хэмжээг бүрэн хангасан Unicity Cleanse-ийг хэрэглэснээр та өдөрт 3-4 удаа их хэмжээгээр хүндэрч, дотор өөхөө арилгаснаар гэдсээрээ нарийсах боломжтой. ЭРҮҮЛ мэндийн UNICITY компанийн CLEANSE цэвэрлэгээний бүтээгдэхүүн хэрэглэснээр маш олон давуу тал бий болдог. Тухайлбал, ядрахаа болино. Хөгшрөлтөөс сэргийлнэ, харшилд

хотоос ч биш хөдөө орон нутгаас ч бидэнд энэ мэт асуудалтай иргэд хандаж, үр дүнг нь үзсэнээ бидэнтэй хуваалцдаг. Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь гэх мэтээр 21 аймагт манай бүтээгдэхүүнийг хэрэглэдэг.

Өтгөн хатагт, илүүдэл жин таны сэтгэлийг зовоож байна уу

Өртөхгүй, өтгөн хатах, гүйлгэх шамбарам зэргээс ангижирна. Мөн хэт таргалж, тухрахгүй. Гэдсээрээ бүдүүрэхээс ангижирч, дархлааны систем сайжрах гэх мэтээр олон давуу талыг бий болгох юм. Мэдэгдэх, мэдэгдэхгүй олон өвчнийг оношлон илрүүлж анагааж байгаа нь уг бүтээгдэхүүний төгс бүтээгдэхүүн болохыг баталж байна. Биеэс шингэгч, олон жилийн хур бохирдолыг цэвэрлэн гадагшлуулж анагаадгаараа онцлог бөгөөд хэрэглээд жингээ хассан, эрүүлжсэн хүмүүс маш олон байна. Бүдүүн нарийн гэдэснийхээ бохирдлоос ангижирсан хүн эрүүд энх, урт удаан насладаг нь судалгаагаар батлагдсан. Цэвэрлэх багц хэрэглэсэн хэрэглэгчид маань ч сэтгэл хангалуун үлддэг. 2009 онд анхны хүүхдээ гаргаснаас хойш өтгөн хатаж эхэлсэн 33 настай хэрэглэгч маань цэвэрлэгээний багцыг хэрэглэснээр өдөрт 4-5 удаа хүндээр бие засдаг болсон байгаа юм. Мөн таарахгүй байсан хувцас нь таарч, өөртөө илүү их итгэлтэй амьдрах болсноо бидэнтэй хуваалцдаа. Мөн Говь-Алтай аймгийн иргэн А ясны бэртлийн улмаас өтгөн хатагт, яс нь бороолохдоо удаан зэрэг шаналгаатай байсан бол Ясны баяжмал, Цэвэрлэгээний багц гэдэс цэвэрлэх цай, цус шингэлдэг замаг хамт захиалж хэрэглэснээр яс нь бороолж, өтгөн хатах зовиураасаа салж чадсан байгаа. Мөн даралтны эм тогтмол хэрэглэж байсан 58 настай Хөвсгөл аймгийн хэрэглэгч маань Омега-3 нэг сар хэрэглээд даралт ихсэх өвчнөөсөө бүрэн салсан, ходоод их өвддөг байснаа"Супер грийн" бэлдмэл хэрэглээд ходоод өвдөхөө больсон хэмээн бидэнд талархлаа илэрхийллээ. Энэ мэтээр хэрэглэгч нэг бүрийнхээ төлөө бид ажиллаж чаддаг.

-Мэдээж бидний ярилцлагыг уншсан хүмүүс та бүхэнтэй холбогдохыг хүсэх нь мэдээж. Хэрхэн холбогдох боломжтой вэ?

-Манайх 25 дугаар эмийн сангийн хажууд байрлах "Кёкүшо цамхаг"-ийн долдугаар давхарт байрлаж байна. 706 тоот өрөөнд ирж уулзах, хэрвээ ирэх боломжгүй байгаа бол 99003733, 88961635, 90000350 утсаар холбогдоорой. Бид таньд бүтээгдэхүүнээ өөрсдөө хүргэж өгөх үйлчилгээг ч үзүүлэх болно.

МЭДЭЭЛЭЛ

Сэлэнгийн хүү Г.Ганбаяр дэлхийд данслагдлаа

Монголын Хөлбөмбөгийн Холбоо, "Пушкаш академи"-ийн хамтын ажиллагааны дагуу өнгөрөгч оны есдүгээр сард Унгарыг зорьсон дөрвөн хөлбөмбөгчин нэг болох Сэлэнгэ нутгийн унаган хүү Ганболдын Ганбаяр "Сузуки цом"-ын хүрэл медалийн эзэн болжээ. "Пушкаш академи" эхний тоглолтоо "Байерн Мюнхэн"-тэй хийхэд Г.Ганбаяр 57 дахь минутад сэлгээгээр орсон нь Монгол хөлбөмбөгчин Европ тивийн тэмцээний тоглолтод оролцсон анхны тохиолдол болсон юм.

Тэгвэл Г.Ганбаяр дахин нэг шинэ түүх бүтээсэн нь "Сузуки цом" тэмцээнд торгуулийн цохилтоос гоол оруулан, багийнхаа хамтаар хүрэл медаль хүртсэн явдал байлаа. "Пушкаш академи", "Будапешт Хонвед" багтай үндсэн цагт 1:1-ээр тэнцэн торгуулийн цохилтоор ялагч тодроход Г.Ганбаяр багийнхаа хоёр дахь цохилтыг амжилттай гүйцэтгэж, ялалт байгуулахад хувь нэмрээ оруулснаар түүхэн амжилт бүтээжээ.

Пушкашийн академийг Б.Амгаланбат, О.Хантэнгэр, Г.Ганбаяр, Д.Тэмүүлэн гэсэн дөрвөн хөлбөмбөгчин хүү зорьсон нь монгол хөлбөмбөгчид анх удаа хилийн чанадад удаан хугацаагаар суралцсан тохиолдол болж байв. Тэгвэл Г.Ганбаяр "Пушкаш академи"-ийн 17 хүртэлх насны багтай дэлхийн хэмжээний тэмцээнд оролцон, гоол оруулж, хүрэл медаль хүртсэнээр европ тивд Монгол Улсын нэрийг гаргасан анхны хөлбөмбөгчин боллоо. Тэмцээнд Европ төдийгүй дэлхийн шилдэг клубүүд болох "Реал Мадрид", "Байерн мюнхэн", "Спортинг", "Панатинаикос", "Будапешт Хонвед" гэсэн шилдэг клубүүд хүч үзсэн билээ. Ийнхүү Сэлэнгэчүүд бүхний түүхэнд явдагаа харуулж, Г.Ганбаяр эх орон элгэн саднаа бахдуулсан сайхан амжилтыг үзүүлж чадлаа.

САГСАНБӨМБӨГ

Кэвин Дурантын тухай таны мэдэхгүй баримт

Б.СУМБЯА

Хойд Америкийн Үндэсний сагсан бөмбөгийн холбооны шигшээ цуврал дуусч, нэг нь ялж нөгөөх нь ялагдлаа. Гэхдээ энэ жилийн тухайд өмнө нь ширүүн өрсөлдөөн дунд хэн ялах нь тодорхойгүй үргэлжилдэг байсан цуврал эхний тоглолтын дараагаас л ойлгомжтой болж эхлэсэн. Улмаар финалын цувралын тав дахь тоглолт Голдэн Стэйт Уорриорсын талбай дээр болон дуусч, Уорриорс 120-129 харьцаагаар хожиж 4-1-ээр цуврал дууслаа. Харин өнгөрсөн зуны хамгийн дуулиантай шийдвэр гаргаж Оакландын багт нэгдсэн Кэвин Дурант аваргын төлөөх тоглолтын Үнэ цэнэтэй тоглолцоор тодров. Тэрбээр аваргын төлөөх таван тоглолтод 35.2 оноо, 8.4 самбараас бөмбөг авч, 5.4 оновчтой дамжуулалт, 55 хувьтай довтолгоог амжилттай болгож, 47 хувьтай холын зайнаас довтолж, 93 хувьтай чөлөөт шидэлтээ шидсэн билээ. Ингээд түүний талаарх төдийлөн мэддэггүй цөөн баримтыг хүргэе.

Тэтгэвэрт гарсныхаа дараа хөгжмийн продюссероор ажиллахыг хүсдэг гэнэ. Оакланд хип хопчидоороо алдартай. Мак Дре, Тоо Шорт, Гоапеле, Кншиа, Коле зэрэг цөөн тооны реперүүд бий. Нэг удаа Кэвин Оакландад "Summer 16 tour" шоу-г зохион байгуулж, түүндээ репер Дрейкийг урьж оролцуулж байжээ.

Дуртай хоол нь наймаалжны хөл. Оакландын багт нэгдсэн Кэвин Дурантын хувьд хоолны асуудалд санаа зоволтгүй бололтой. Учир нь түүний дуртай хоолоор үйлчилдэг "AlaMar", "Smelly's Creole", "Jack's Oyster Bar & Fish House" зэрэг ресторонууд байдаг аж.

Хүмүүнлэгийн үйлст гар татдаггүй. Тэрбээр олон нийтийн үйл ажиллагаанд бэлэн мөнгө хийгээд цаг хугацаа их зарцуулдаг гэнэ. Өөрөө ч үүндээ дуртай аж. Тухайлбал, Улаан загалмайн нийгэмлэгт нэг сая ам.долларыг хандивлаж байжээ.



Кэвин Дурантын хэдэн ч удаа үзсэн хэзээ ч уйдаж байгаагүй кино нь "Big Momma's House" гэнэ. Энэ кино 2012 онд дэлгэцнээ гарч байсан юм. Сонирхолтой нь, КД өөрөө "Thunderstruck" кинонд дүр бүтээж байв.